

**ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

(2024 оны эхний хагас жилийн байдлаар)

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин (хүрээгүй бол шалтгаан, нөхцлийг тайлбарлах)	Гүйцэтгэлийн хувь
2.5.1. Нийгмийн даатгалын шинэчлэл хийж, иргэн бүрд суурь тэтгэвэр олгох, хувийн даатгалын үйлчилгээнд хамрагдах боломж бүхий олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжинэ.	1.	Нийгмийн даатгалын эрх зүйн орчинг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.	-	Нийгмийн даатгалын эрх зүйн шинэчлэл хийгдээгүй, олон давхаргат тэтгэврийн тогтолцоо бүрдээгүй байна.	Нийгмийн даатгалын эрх зүйн орчин шинэчлэгдэж олон давхаргат тэтгэврийн тогтолцоо бүрдсэн байна.	Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан Нийгмийн даатгалын багц хуулийн хүрээнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлж, даатгуулагч санхүүгийн олон эх үүсвэрээс тэтгэвэр авах талаар зохицуулалт орсон. Үүнд: - 1-р давхарга: Тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэвэр; - 2-р давхарга: Хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр /сайн дурын үндсэн дээр/;	100%
	2.	Иргэн бүрд суурь тэтгэвэр олгох эрх зүйн орчинг бүрдүүлнэ.	-	Иргэн бүрд суурь тэтгэвэр олгох, хууль, эрх зүйн орчин бүрдээгүй байна.	Иргэд суурь тэтгэвэр авах эрх зүйн орчин бүрдсэн байна.		70%
	3.	Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.	-	Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын хууль, эрх зүйн орчин бүрдээгүй байна.	Иргэд хувийн тэтгэврийн даатгалд даатгуулах эрх зүйн орчин бүрдсэн байна.		Тэтгэврийн тогтолцоог шинэчилж олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх бодлогын хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн үзэл баримтлал, төсөл, танилцуулга бэлтгэх Ажлын хэсгийг холбогдох төрийн болон олон нийтийн байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулан байгуулж, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлснээр Улсын Их Хуралд өргөн барьсан болно.
2.5.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны	1.	Олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжих эрх	-	Хууль эрх, зүйн орчин бүрдээгүй байна:	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн тодорхой	Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 29 дүгээр зүйлд “Тэтгэврийн нөөц сан бүрдүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх” харилцааг зохицуулсан.	100%

<p>үлдэгдлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.</p>		<p>зүйн орчны хүрээнд тэтгэврийн даатгалын шимтгэлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.</p>			<p>хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх эрх зүйн орчин бүрдсэн байна.</p>	<p>Тэтгэврийн санхүүжилтийн хагас хуримтлалын тогтолцоонд шилжих зорилтын хүрээнд нэрийн дансны орлогыг үе шаттайгаар мөнгөжүүлж тэтгэврийн нөөц сан байгуулах, улмаар уг орлогын тодорхой хэсгийг даатгуулагчийн хууль ёсны өв залгамжлагчид нь 2030 оноос эхлэн өвлүүлэхээр зохицуулсан.</p> <p>2024 оны эхний 4 сарын байдлаар нөөц санд 76.2 тэрбум төгрөг байршаад байна.</p> <p>Тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан журмыг “санхүү, төсвийн, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар батална” гэж заасны дагуу уг журмыг Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан.</p>	
<p>2.5.4. Хөдөлмөрийн зах зээлийг орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчилж, бүтээмж, үр дүнд суурилсан цалин хөлс, ажлын үнэлгээний систем нэвтрүүлж, зайнаас болон цагаар ажиллах уян хатан зохицуулалт бий болгон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.</p>	<p>1.</p>	<p>Хөдөлмөрийн зах зээл, ажилгүйдлийн даатгалын эрх зүйн орчныг шинэчилж, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлнэ.</p>	<p>-</p>	<p>Ажилгүйдлийн даатгалын сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн уялдаа холбоо хангалттай биш.</p>	<p>Ажилгүйдлийн даатгалын тогтолцоог шинэчлэх бодлого, төсөөлөл, судалгаа хийгдэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомжтой нийцүүлсэн байна</p>	<p>Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэн баталсан.</p> <p>Нийгмийн даатгалын ерөнхий хуульд ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос ажилгүйдлийн даатгалын санд төлөх шимтгэлийн 0.2 хувийг 0.5 хувь болгон сан хооронд шилжүүлэн зохицуулалт хийсэн.</p> <p>Ажилгүйдлийн тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлсөн сарыг харгалзан ажилгүй болохын өмнөх шимтгэл төлсөн сүүлийн дараалсан 3 сарыг 9 сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас 45, 50 хувиар олгодог байсныг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын минимум стандартад нийцүүлэн 50, 55, 60, 70 хувиас тооцож олгохоор болсон.</p> <p>Мөн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад ажлын байранд даатгуулагчийг тогтвор суурьшилтай урт хугацаанд ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх, даатгуулагчийг ажилгүй болохоос урьдчилан сэргийлэх, зорилгоор ажил олгогчид 5 жилд 1 удаа 10 хувиар шимтгэлийн хөнгөлөлт үзүүлж байсан бол 3 жилд нэг удаа 15 хувиар хөнгөлөлт үзүүлэхээр баталсан.</p>	<p>100%</p>

2.5.5 Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг инфляц, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан шаттайгаар нэмэгдүүлнэ.	2.	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг инфляцийн түвшинтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	Улсын төсөв	Бүрэн тэтгэврийн доод хэмжээ 550.0 мян төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 440.0 мян.төгрөг	Инфляцийн түвшинтэй уялдуулан тэтгэврийн хэмжээ нэмэгдсэн байна.	<p>Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулж жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлэхээр, уг зохицуулалтыг 2025 оноос мөрдөхөөр заасан.</p> <p>Мөн Засгийн газрын 2024 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 120 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 2024 оны 4 сарын 1-ний өдрөөс эхлэн 100.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 650.0 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 540.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.</p> <p>Тэтгэврийн нэмэгдэлд 499.2 мянган тэтгэвэр авагч хамрагдах бөгөөд 2024 онд 449.0 тэрбум төгрөг зарцуулна.</p>	100%
	3.	Тэтгэврийн зөрүүг ойртуулах зорилгоор тэтгэвэр тооцох итгэлцүүрийг шинэчлэн тогтооно.	-	Засгийн газрын 2023 оны 238 дугаар тогтоолоор тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг тогтоосон.	Тэтгэвэр тооцох итгэлцүүрийг шинэчлэн тогтоосон.	<p>Засгийн газрын 2023 оны “Итгэлцүүр шинэчлэн батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 238 дугаар тогтоолоор тэтгэвэр бодоход баримтлах цалингийн итгэлцүүрийг шинэчлэн баталсан. баталсан итгэлцүүрээр өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны болон цэргийн тэтгэвэр авч байсан 488.1 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийг шинэчлэн тогтоох ажлыг зохион байгуулсан арга хэмжээний хүрээнд 2023 оны 06 дугаар сарын байдлаар тэтгэвэр авч байсан 488.1 мянган хүнээс 164.6 мянган хүний тэтгэвэр итгэлцүүр хэрэглэснээр дунджаар 188.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн. Эдгээр иргэдийн тэтгэврийн нэмэгдэлд 2023 онд 200.1 тэрбум төгрөгийг зарцуулав.</p> <p>Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу Засгийн газрын 2024 оны “Итгэлцүүр тогтоох тухай” 10 дугаар тогтоолоор тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг шинэчлэн баталсан.</p>	100%
2.5.6 “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд	2.	Нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд ил тод, түргэн шуурхай, хүртээмжтэй цахим	100.0 Гадаадын зээл тусламж	Нийгмийн даатгалын үйлчилгээний 80 хувь цахимжсан.	Нийгмийн даатгалын үйлчилгээг бүрэн цахимжуулсан байна.	<p>“Цахим Монгол” арга хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд иргэд даатгуулагч, ажил олгогч, төрийн болон бусад байгуулагуудад нийгмийн даатгалын үйлчилгээг цаг хугацаа, орон зайн хамааралгүйгээр <b>24/7</b> цагийн горимоор цахим хэлбэрээр шуурхай хүргэн ажиллалаа.</p> <p>Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 30 шахам жилийн турш өөр өөр цаг хугацаанд янз бүрийн технологи дээр хийгдсэн олон программ хангамж ашиглагдаж байсан</p>	70%

<p>нь цахимжуулах, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, түргэн шуурхай, хүртээмжтэй болгоно.</p>		<p>хэлбэрээр хүргэнэ.</p>				<p>бөгөөд эдгээрийг ашиглан нийгмийн даатгалын үйлчилгээний 80 хувийг цахимаар үзүүлж байсан.</p> <p>2024 оны 01 дүгээр сараас эдгээр программ хангамжуудыг сүүлийн үеийн дэвшилтэт технологид суурилсан, уян хатан, динамик суурьтай, бодит цагийн горимд ажиллах мэдээллийн нэгдсэн систем болгон шинэчлэн нэвтрүүлсэн.</p> <p>Уг систем нь дэвшилтэт технологид суурилсан тул бусад байгууллагуудын дэд системүүдтэй уялдан ажиллах боломж нь нэмэгдэж иргэд даатгуулагч, ажил олгогч, харилцагч байгууллагуудад үзүүлж буй нийгмийн даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний цахимжих үйл ажиллагаа улам сайжирах нөлөөтэй.</p> <p>Мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлсэнтэй уялдуулан иргэд даатгуулагч, ажил олгогчийн мэдээллүүдийг агуулсан, 120 орчим төрлийн сервисийг шинэчлэн боловсруулж Төрийн мэдээлэл солилцооны ХУР системд байршуулж 24/7 цагийн горимд цахимаар үйлчилээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.</p> <p>2024 оны эхний хагас жилийн байдлаар ХУР системийн нийт хандалтын тоо <b>1.4 саяд</b> хүрч иргэд даатгуулагч, ажил олгогч, төрийн болон бусад байгууллагууд дараах үйлчилгээнүүдийг цахимаар авсан байна. Тухайлбал:</p> <p><b>Иргэний болон ажил олгогчийн цахим системээр:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- <b>79.7 мянган</b> хүсэлт цахимаар хүлээн авч 88.1 хувийг нь шийдвэрлэсэн;</li> <li>- <b>9.0 мянган</b> даатгуулагч сайн дураар даатгуулах гэрээ байгуулах, төлбөрөө төлөх үйлчилгээнд цахимаар хамрагдсан;</li> <li>- <b>50.0 мянган</b> даатгуулагч, ажил олгогч QR кодтой шимтгэл төлөлтийн лавлагаа, тодорхойлолтоо цахимаар авсан;</li> <li>- Давхардсан тоогоор <b>255.1 мянган</b> ажил олгогч <b>4.1 сая</b> албан журмын даатгуулагчийн 2024 оны 1, 2, 3, 4, 5 сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг цахимаар илгээснийг хүлээн авсан;</li> <li>- <b>1,034</b> эрүүл мэндийн байгууллагаас <b>88.2 мянган</b> даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, <b>29.5 мянган</b> даатгуулагчийн жирэмсний болон амаржсаны</li> </ul>
--	--	---------------------------	--	--	--	--

					<p>тэтгэмжийн, нийт <b>117.7 мянган</b> эмнэлгийн хуудас цахимаар хүлээн авч үүнээс <b>87.0 мянган</b> тэтгэмжийн тооцооллыг хийж үйлчилгээ үзүүлсэн;</p> <p><b>Лавлагаа, тодорхойлолт шалгах вэб систем:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Элчин сайдын яамдууд, банк, санхүүгийн байгууллагаас <b>2.1 мянган</b> ажил олгогч, <b>16.6 мянган</b> даатгуулагчийн шимтгэл төлөлтийн QR кодтой тодорхойлолтыг шалгасан байна.</li> </ul> <p><b>E-Mongolia нэгдсэн портал:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- <b>331.3 мянган</b> иргэд даатгуулагч, ажил олгогч <b>8 төрлийн</b> лавлагаа тодорхойлолтоо цахимаар авсан байна.</li> </ul> <p><b>ТҮЦ машин:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн үйлчилгээний 109 машинаас иргэд, даатгуулагч, ажил олгогч нийгмийн даатгалын 4 төрлийн лавлагаа, тодорхойлолтоо хэвлэн авч байна.</li> </ul> <p><b><u><a href="http://www.opendata.gov.mn">www.opendata.gov.mn</a></u>:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйл, Засгийн Газрын 2022 оны 232 дугаар тогтоолоор баталсан "Нээлттэй өгөгдлийн жагсаалт", 200 дугаар тогтоолоор баталсан "Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам"-ын дагуу <b>2023 оны жилийн эцсийн байдлаарх</b> нийгмийн даатгалын <b>16 нэр төрлийн</b> нээлттэй мэдээллийг тус бүр 4 форматаар хувирган <u><a href="http://www.opendata.gov.mn">www.opendata.gov.mn</a></u> болон <u><a href="http://www.ndaatgal.mn">www.ndaatgal.mn</a></u> веб сайтуудад цаг хугацаанд нь байршуулсан.</li> </ul>	
<b>ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ</b>					<b>91.2 %</b>	